

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2018 оны 03 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 002


Улаанбаатар
хот

Хэвлэл, мэдээллийн зөвлөл
байгуулах тухай

Засгийн газрын 2011 оны 323 дугаар тогтоолоор батлагдсан “Жендэрийн үндэсний хорооны дүрэм”-ийн 2.2, 2.7-д заасныг үндэслэн Хорооны хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Жендэрийн үндэсний хорооны дэргэд Хэвлэл, мэдээллийн зөвлөл байгуулсугай.
2. Хэвлэл, мэдээллийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг батлан зөвлөлийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг хорооны Нарийн бичгийн дарга үүрэг болгосугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хэвлэл мэдээллийн зөвлөл” байгуулах тухай Жендэрийн үндэсний хорооны 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ДАРГА



У.ХҮРЭЛСҮХ